



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2023 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 105

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл  
олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 4 дэх заалт, Дорнод аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2021 оны 75, 56 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Дорнод аймгийн өмчөөс шилжүүлсэн 4 нэрийн, нийт 1,377,187,527.13 (нэг тэрбум гурван зуун далан долоон сая нэг зуун наян долоон мянга таван зуун хорин долоон төгрөг арван гурван мөнгө) төгрөгийн балансын үнэ, 195,428,475.13 (нэг зуун ерэн таван сая дөрвөн зуун хорин найман мянга дөрвөн зуун далан таван төгрөг арван гурван мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг төрийн өмчид хүлээн авч хавсралтад заасан төрийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Хавсралтад заасан төрийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирагч Дорнод аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Н.Гэрэлцэцэг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Шилжүүлэн авч буй үл хөдлөх хөрөнгөд хамаарах газар эзэмших эрхийг шилжүүлэн баталгаажуулах асуудлыг шийдвэрлэх;

2.3. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132004805  
9-r\_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2023 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн  
165 дугаар тогтоолын хавсралт

Дорнод аймгийн өмчөөс шилжүүлсэн, төрийн өмчит хүлээн авч бүртгэх хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Байршил	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)	Эзэмшигч байгууллагын нэр	Шилжүүлэх авах байгууллагын нэр
1	Тоёота Ланд крузер-200 маркийн суудлын автомашин, улсын дугаар 00-01 ДОА, арлын дугаар JTMHX05J204067210	Дорнод аймаг	2014	1	159,900,000.00	122,590,000.00	37,310,000.00	Дорнод аймгийн ЗДТГ	Дорнод аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төв
2	Ерөнхий боловсролын сургуулийн дундын корпус	Дорнод аймгийн Халх гол сум	1976	1	584,553,005.82	49,831,158.82	534,721,847.00	Ерөнхий боловсролын сургууль	Хил хамгаалах ерөнхий газрын хилийн цэргийн 0198-р анги
3	Үйлдвэр барилга /хуучин/	Дорнод аймгийн Халх гол сум	1976	1	422,806,574.62	13,880,014.62	408,926,560.00	Халх гол сумын ЗДТГ	Бүсийн төв Дорнод аймгийн Онцгой байдлын газар
4	Соёлын төвийн барилга /хуучин/	Дорнод аймгийн Халх гол сум	1975	1	209,927,946.69	9,127,301.69	200,800,645.00	Халх гол сумын Соёлын төв	Бүсийн төв Дорнод аймгийн Онцгой байдлын газар
					<b>1,377,187,527.13</b>	<b>195,428,475.13</b>	<b>1,181,759,052.00</b>		
<b>НИЙТ ДҮН</b>					(нэг тэрбум гурван зуун далан долоон сая нэг зуун наян долоон мянга таван зуун хорин долоон төгрөг арван гурван мөнгө) (нэг тэрбум нэг зуун таван сая дөрвөн зуун хорин найман мянга дөрвөн зуун далан таван төгрөг арван гурван мөнгө) (нэг тэрбум нэг зуун наян долоон зуун долоон сая хоёр)				